



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 07-р сарын 07 өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Гадаадад хүн сургах тухай

ТУШААХ НЬ:

1. М. Батыг Бизнесийн удирдлагын мэргэжлээр АНУ-ын Виржинийн Их Сургуульд 2 жилийн хугацаагаар магистрантурт, Жанжаагийн Батсайханыг ОХУ-ын Дотоод явдлын яамны удирдлагын академид 1999/2000 оны хичээлийн жилээс эхлэн 3 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж холбогдох төлбөр тооцоог хийхийг "Сургалтын төрийн сан"-ийн захирал Б.Ганбатад, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг "Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар"-ын дарга С.Алтангэрэлд тус тус даалгасугай.



САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

А.БАТТӨР